



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



JAPAN GOV  
THE GOVERNMENT OF JAPAN



THE WORLD BANK  
1818 H ST. N.W. WASHINGTON, DC 20561



Save the Children

# ЭНТРЕПРЕНЕР SEEDS



Тэтгэлэг горилогч хүүхэд,  
залууст зориулав

ХАРИЛЦАН СУРЪЯ  
ХАМТДАА БҮТЭЭЕ



ОРОН НУТГИЙН ӨСВӨР ҮЕИЙНХЭНД  
ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАР, ЭНТРЕПРЕНЕРШИП  
БОЛОВСРОЛ ОЛГОХ ТӨСӨЛ

# ТЭТГЭЛГИЙН ГАРЫН АВЛАГА


## ТӨСЛИЙН ТЭТГЭЛЭГ ГОРИЛОГЧДОД ЗОРИУЛАВ



Сэтгэлгээ



Мэдлэг



Ур чадвар

ISBN: 978-9919-9679-2-5

Энэхүү гарын авлага нь Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрийн өмч бөгөөд албан ёсны зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.



## Та аль бүлэгт хамаарах вэ?

Би 8-12 дугаар ангид сурдаг  
Ерөнхий Боловсролын  
Сургуулийн сурагч

Би 14-25 настай,  
Насан Туршийн Боловсролын  
төвийн суралцагч

Би тэтгэлэг горилогчийн  
гэр бүлийн төлөөлөл

Би багш / зөвлөх

Би төслийн аймаг/сумын  
зөвлөлийн гишүүн

Би төслийн  
орон нутгийн ажилтан

 Энэхүү гарын авлагыг танд зориулав.

# [ Агуулга ]



# 1

WHY NOW

# 2

SCAN

# 3

FOCUS

## ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА 1

Яагаад энэ төсөл гэж?	3
ESEL сургалтын хөтөлбөр	4
Би юу хийх хэрэгтэй вэ?	6
Хамрах хүрээ	7
Оролцогч талууд	8

## БИД ОРОЛЦЪЁ 10

Төсөл шалгаруулах тэмцээнд хэн оролцох вэ?	11
Төсөл шалгаруулах тэмцээнд яаж оролцох вэ?	12

## ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗАГВАР 14

Төсөл бичих дараалал	15
Жишээ төслийн санаанууд	16
Анхаарах 7 зүйлс	18
Төслийн боломжит чиглэлүүд	20
Үл зөвшөөрөгдөх төслийн санаанууд	21

GENERATE  
4

НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД  
ҮЗҮҮЛЭХ БИДНИЙ НӨЛӨӨ 23

Нийгмийн болон хүрээлэн буй  
орчны нөлөөллийн үнэлгээ хийх 24

Төсөл илгээх зааварчилгаа 36

Төсөл сонгон шалгаруулалт хэрхэн  
явагдах вэ? 37

Шүүгчдийн онооны шалгуур  
үзүүлэлтүүд 38

Тэмцээний дараах үе шат 40

EXECUTE

5

ТЭТГЭЛЭГ АВАХ  
ЗААВАРЧИЛГАА 43

Тэтгэлгийн гэрээ зурах талууд 44

Тэтгэлэг хэрхэн хүлээн авах вэ? 45

Худалдан авалтын тухайд 47

Төсөлд өөрчлөлт оруулах тухайд 48

Тэтгэлэгт санхүүжилт дуусгавар  
болох үе шат 49

CULTURE  
6

ЁС ЗҮЙ БА АШИГ СОНИРХЛЫН  
ЗӨРЧЛИЙН БОДЛОГО 51

Ашиг сонирхлын зөрчлийн тухай 52

Оролцогч талуудын шууд бус ашиг  
сонирхол 53







- Могоор Рубеи

**ТА МӨРӨӨДӨЖ ЧАДВАЛ  
БТЭЭЖ БАС ЧАДНА.**

# Яагаад энэ төсөл гэж?

ОРОН НУТГИЙН ӨСВӨР ҮЕИЙНХЭНД  
ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАР, ЭНТРЕПРЕНЕРШИГ  
БОЛОВСРОЛ ОЛГОХ ТӨСӨЛ

*Аливаа улс орны хамгийн чухал үнэт зүйл бол хүн, харин хөгжлийн түлхүүр нь биет бус үнэ цэнэ буюу тухайн ард иргэдийн оюуны сэтгэлгээ, хамтын хөдөлмөр байдаг. Харин техник технологийн шинэчлэл хурдацтай явагдаж буй өнөө үед хүн төрөлхтөн дасан зохицохуйн хүрээнд аливаад зайлшгүй бүтээлчээр хандаж, асуудлыг шийдэл болгон зорих мэдлэг, ур чадварыг эзэмших зайлшгүй шаардлагатай болсон.*

*Иймээс бид Дэлхийн банк болон Япон улсын Нийгмийн хөгжлийн сантай хамтран хөдөө орон нутагт амьдарч буй хүүхэд, залуусыг бүтээлч сэтгэлгээгээр дамжуулан орон нутагтаа шинэлэг өөрчлөлт авчрах энтрепренер сэтгэлгээтэй залуусыг дэмжих энэхүү төслийг хэрэгжүүлж байна.*

*Японы Хүүхдийг Ивээх Сан*

# ESEL сургалтын хөтөлбөр



Өөрийгөө ойлгох,  
танин мэдэх



Энтрепренершип  
суурь мэдлэг



Нийгэм, соёлын  
орчлыг танин  
мэдэх



Бизнес төлөвлөлт



Бүтээлч байдал,  
инноваци



Санхүүгийн мэдлэг

Сэтгэлгээ Мэдлэг Үр чагвар




Өсөлтийн сэтгэлгээ



Энтрепренер сэтгэлгээ

Энтрепренер хүн  
үргэлж шинэ  
санаа, шинэ  
шийдлийн  
хойноос явж  
байдаг.



Тунгаан бодох  
болон харилцах

Нөөцийн зохистой  
хуваарилалт  
төлөвлөгөө  
боловсруулах,  
хэрэгжүүлэх


Багаар ажиллах

Дижитал мэдлэг  
болон  
Ёс зүйн талаарх  
ойлголт

Ур чадвар гэж юу вэ ?

Ур чадвар нь төрөлхийн биш бөгөөд шаргуу хөдөлмөр, туршлагын үр дүнд хөгждөг. Тиймээс бид алдаа хийхээс айх бус алдаанаас суралцдаг байх нь хувь хүний ур чадвараа сайжруулах, хөгжүүлэхэд чухал гэдэгт итгэл үнэмшилтэй болно.

# Би юу хийх хэрэгтэй вэ?



## Хамрах хүрээ

Энтрепренер сэтгэлгээ суулгах, мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх ESEL сургалтад хамрагдах

Бүтээлч шийдэл шалгаруулах тэмцээнд багаараа оролцох

Хүүхдийг Ивээх Сангийн шийдвэрээр шалгарсан багууд тэтгэлэг авах

Тэтгэлэг авсан багууд менторуудаас туслалцаа авах



## Оролцогч талууд

Хүүхдийг  
Ивээх Сан



Тэтгэлэг  
горилогч баг

Төслийн  
аймаг/  
сумын  
зөвлөл



Сургуулийн  
багш нар  
зөвлөхүүд




Орон нутгийн дадлага  
туршлагатай жижиг,  
дунд бизнес эрхлэгчид  
болон нийгмийн  
энтрепренерууд

Менторууд



*Бид бүгдээрээ хамтран  
ажиллаж, бүтээлч  
шийдлээ хэрэгжүүлнэ.*







-Келпү Попг



# Би

---

# Оролцъё

---

- Тэтгэлгийн шалгаруулалтад хэрхэн хамрагдах вэ?

# Төсөл шалгаруулах тэмцээнд хэн оролцох вэ?

## 1-Р ҮЕ ШАТ

Төслийн зорилтот сумын иргэн байх

14-25 насны НТБ төвийн суралцагчид

ЕБС-ийн  
9-12 дугаар ангийн  
сурагчид



НТБ төвд суралцагчдын хувьд энэхүү тэтгэлэг нь орон нутгийн хүрээнд хийж болох гарааны бизнесийн эхлэлийн хөрөнгө юм.



Ментортой  
хамтран ажиллах



Төслийн ESEL  
сургалтын хөтөлбөрийг  
бүрэн дүүргэсэн байх

- 3-6 хүнтэй баг бүрдүүлж тэмцээндээ оролцох



Өөрийн хэрэгжүүлэхийг хүсэж буй шинэлэг санаатай эсвэл шийдэх хэрэгтэй асуудлыг нээн олж илрүүлсэн

### Анхаарах зүйлс

• ЕБС-д сурагчдын багийн гишүүд нь зөвхөн дунд эсвэл ахлах ангийн сурагчдаас бүрдэх



• Багийн гишүүдийн хүйсийн тэнцвэртэй байдал



• Баг бүр удирдагч мөн зөвлөх багштай байх  
• Төслийн хугацаа 3-6 сар байх



# Төсөл шалгаруулах тэмцээнд яаж оролцох вэ?

## 2-Р ҮЕ ШАТ

6  
CAP

Төслийн санааг хэрэгжүүлэх салбар нь тухайн сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл болон эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй нийцтэй байх

Төсөл 6 сар тогтвортой хэрэгжих боломжтой байх, шаардлагатай нөөц тухайн орон нутагт байдаг, энэ нөөцийг сумын засаг захиргаа болон сургуулиар дамжуулан ашиглах боломжтой

Тодорхой хэмжээний ашигтай ажиллах боломжтой байх

Төслөө танилцуулах ур чадвар сайтай байх



Хүний нөөцтэй байх  
Багийн гишүүдийн ажил үүрэг, хариуцлага тодорхой, тэгш хуваарилалттай байх

БҮТЭЭЛЧ,  
ШИНЭЛЭГ  
САНААТАЙ  
БАЙХ






- Бенжамин Франклин



**Төсөл  
Боловсруулах  
Загвар**

# Төсөл бичих дараалал



# ЖИШЭЭ ТӨСЛИЙН САНААНУУД:

★★★★  
**01** **ТС**  
.....  
Төслийн санаа

Эвдэрхийг эв дүйгээр


Технологийн багшийн дэмжлэгтэйгээр сургуулийн эвдэрхий ширээ сандлыг засах, шинэ загвар хийх хосолсон төсөл



★★★★  
**02** **ТС**  
.....  
Төслийн санаа

Чулуун тоглоомны бренд

Байгаль дээрх чулууг онцгой дүрс бүхий сийлбэр, хэлбэрт оруулж тоглоом зохиох төсөл



★★★★  
**03** **ТС**  
.....  
Төслийн санаа

Та мэдэх үү? газрын зураг

Өөрийн амьдарч буй аймаг сумынхаа газрын зургийг бүхий л содон хүмүүс, соёлын өв болон бизнесүүдийг өвөрмөц байдлаар дүрслэн хэвлүүлж жуулчдад борлуулах төсөл



★★★★  
**04** **ТС**  
.....  
Төслийн санаа

Эвлэрүүлэх үйлчилгээ

Сургууль дээр чинь хэсэг суралцагчид маргалдсан уу? Тэгвэл тэрхүү маргааны учрийг олох буланг байгуулах төсөл



★★★★  
**05** **ТС**  
.....  
Төслийн санаа

Шидэт хогийн сав


Сургууль, эмнэлэг, дэлгүүр болон тамгын байранд зориулан ялган ангиллах шидэт хогийн савийг үйлдвэрлэх төсөл



★★★★  
**06** **ТС**  
.....  
Төслийн санаа


Хог хаягдлаар бүтээгдэхүүн хийх клуб

Сургууль дээр хамгийн их хаягддаг чихэр, жигнэмэг, чипсний цаас болон хэрэглсэн дэвтэр, бал, үзгээ ашиглан бэлэг, дурсгалын зүйлс хийх төсөл





# ЖИШЭЭ ТӨСЛИЙН САНААНУУД:



★★★★★  
**07** **ТС**  
.....  
Төслийн санаа


**Соёл урлаг, спортын клуб**

*Хичээлээс гадуур утга зохиол, соёл урлаг, гар урлал, илтгэх урлаг, уран зураг, фото зураг, спорт зэрэгт сонирхолтой сурагчид сумаа танилцуулах хөтөлбөр гаргах төсөл*

★★★★★  
**08** **ТС**  
.....  
Төслийн санаа

**Дижитал клуб**


*Интернет блог, сургуулийн интернет сонин, цахим технологийн клубууд*



★★★★★  
**09** **ТС**  
.....  
Төслийн санаа

**Хоолны клуб**


*Нутгийн амт, ёс заншлыг агуулсан маш өвөрмөц хоолны цэс гарган, олон нийтэд танилцуулдаг, онцгой хэлбэр дүрс ашиглан хийсэн эрүүл мини хоол, зууш хийдэг сургуулийн бренд клуб*



★★★★★  
**10** **ТС**  
.....  
Төслийн санаа

**Био клуб**

*Биологийн холбогдолтой сонирхолтой туршилт, шинжилгээ хийдэг клуб: Жишээ нь бордооны шинэ найрлага бүтээх, чийгийн улаан хорхой, малын бууц, зэрлэг ургамалаар бордоо хийх зэрэг*



★★★★★  
**11** **ТС**  
.....  
Төслийн санаа

**Органик хүнс**


*Дэлхийн жишигт нийцэхүйц стандартаар органик нарийн ногоо тарьж ургуулдаг клуб*



★★★★★  
**12** **ТС**  
.....  
Төслийн санаа

**Танай суманд шинэлэг санаа**

*Сум, орон нутгийн иргэдийн хэрэгцээг хангах шинэлэг төсөл*



# Бизнес төсөл бичихэд анхаарч үзэх 7 зүйлс

## Эхлэх цэг: Хэрэглэгч

Төсөөлөх  
=  
Бодох  
=  
Ажиллах

Ганцаараа бүү нис:  
"Олны хүч оломгүй  
далай"

Хийгээд, хуваалц  
"Үлгэр сайн бол  
үйл нь сайн "

Хүн бүрд асуудал байдаг. Аль асуудлыг сонгож авч шийдлийг олох нь танай багийн сонголт. Харин зөв шийдэл олсон эсэхээ яаж мэдэх вэ? Амархан, танай бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэх хүн төвөггүй хэлээд өгнө. Иймээс анхнаасаа хэрэглэгчээ зөв ойлгож, **хэрэгцээг нь зөв тодорхойлох** нь чухал. Харин хайсан хариулт тань **зөв асуултаас** олдоно.

Яагаад орчин цагийн урлаг дундаас кино урлаг хамгийн залуу нь мөртөө, хүмүүс нийтээрээ онцолж үздэг болохыг мэдэх үү? Хийх гэж буй зүйлээ төсөөллөө ашиглан зургаар, **нүдэнд харагдахуйц байдлаар илэрхийлэх** нь танай багт аливаа зүйлийг илүү тод томруун бодитоор харж, нарийн төвөгтэй сэдвүүдийг ойлгомжтой харагдуулж, сонсогчдодоо **өөрийн санаагаа ойлгуулахад** чухал үүрэгтэй.

Хөл бөмбөгт багийн гишүүд бүгд гайхалтай довтлогчид байвал энэ баг ялахгүй Энэ жишээ зөвхөн хөл бөмбөгт ч бус бусад салбарт ч мөн адил үйлчилдэг. **Төрөл бүрийн авьяастай**, өөр өөр онцлогтой хүмүүс их байх тусам танай багийн ялах магадлал ихэснэ. Багийнхаа гишүүдийн мөн өөр өөр салбар дахь хүмүүсийн **үзэл бодол, ойлголтыг сонсож цуглуулснаар** далд нуугдсан боломжийг олж харах болно.

Өвөг дээдсээс уламжлагдан ирсэн үлгэр домог бичигдэж үлдээгүй мөртөө хэрхэн он удаан жилийн туршид хадгалагдан ирсэн юм бол гэж бодож байсан уу? Үүний учир хүн бид ямар ч төрлийн мэдээллээс үлгэр, түүхийг илүүтэй тогтоодог, дуртай байдаг юм. Иймээс хийж буй зүйлдээ заавалчгүй энэ санаа хаанаас анх бий болсон, хийж байхад юу тохиолдсон гэх зэрэг дурсамжтай **түүхээр өгүүлээрэй.**



## Энгийн бай!

Iphone утас яагаад хамгийн бага товчлууртай хирнээ манай эрин-ы хамгийн гайхалтай бүтээлүүдийн нэгээр шалгарсан юм бол?

Хамгийн эцсийн бүтээгдэхүүн, эцсийн шийдлээ олох гэж **яарах хэрэггүй**. Илүү зардал гаргах, гол асуудалтай шууд хамааралгүй зүйлүүдээс салахыг хичээгээрэй.



~~Их~~ > Бага

## Жижиг, жижиг туршилт хий

Бодит байдал, таны бодол хоёр үнэн хэрэг дээрээ маш их зөрүүтэй байх болно. Энэ зөрүүг багасгах ганц зүйл бол туршилт хийж, шинээр ойлголтууд бий болгох явдал.

## Цаг цагаараа байдаггүй, цахилдаг **хөхөөрөө...**

*Ковид-19 цар тахал гарахад хэнд хамгийн их нөлөө үзүүлсэн бэ?*

Хувьсах өөрчлөлтөөс өөр тодорхой зүйл гэж байдаггүй. Үүнийг хүлээн зөвшөөрч, үүсч болох тодорхойгүй нөхцөл байдлаас шинэ боломжуудыг эрэлхийлээрэй.

# Төслийн боломжит чиглэлүүд :

1

Худалдаа, үйлчилгээний төрлийн бизнес санаа

1. Аялал жуулчлалын хүрээнд хэрэгжүүлж болох үзэсгэлэнт газруудтай холбоотой бүтээгдэхүүн үйлчилгээ, цахилгаан электроникийн засвар, гар урлал, хоол хүргэлтийн үйлчилгээ, гэрэл зургийн студи эсвэл урлагийн студи, номын дэлгүүр ажиллуулах;

3

ХАА, хүнсний бизнес санаа

3. Органик бренд бүтээгдэхүүн хийх, фермийн аж ахуйг дэмжсэн /малын тэжээл, газар тариалан, малын эрүүл мэндтэй холбоотой бизнес санаа/, ногоо тарих, даршлах зэрэг уламжлалт бизнесийг орчин үеийн шинэлэг аргачлалтай хослуулсан бизнес санаанууд байж болох ба мал аж ахуйгаас байгальд учруулдаг сөрөг нөлөөллийг бууруулахын тулд боловсруулсан түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн хийх санаануудад давуу эрх олгох болно;

2

Овор багатай үйлдвэрлэлийн бизнес санаа

2. Малын гаралтай түүхий эд болон бусад материал ашиглан бүтээгдэхүүн хийх санаа: Гар хийцийн бүтээгдэхүүн (арьс, ноосон урлал, сүүн бүтээгдэхүүн, хувцас, гутал, нэхмэл эдлэл, тоглоом г.м)

4

Мэдээлэл ба технологийн бизнес санаа

4. Интернет кафе, мэдээлэл технологи болон дрон камер ажиллуулах/түрээсийн үйлчилгээ, гар утасны аппликейшн, орон нутгийн цахим блог/сэтгүүл хөтлөх;

## Үл зөвшөөрөгдөх төслийн санаанууд

- Цацраг идэвхт материал ашиглах аливаа үйл ажиллагаа;
- Үйлдвэрлэлийн мод бэлтгэл;
- Зөвшөөрөлгүй загас агнуур;
- Генийн инженерчлэлтэй организмыг нэвтрүүлэх;
- Мөрийтэй тоглоом, казино, түүнтэй адилтгах байгууллагууд;
- Уул уурхай, ашигт малтмал;
- Хар тугалган будагны үйлдвэрлэл;
- Тамхины үйлдвэрлэл, худалдаа;
- Цацраг идэвхт материал үйлдвэрлэл, худалдаа;
- Полихлорт бифенил (ПХБ) агуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа;
- Согтууруулах ундаа үйлдвэрлэл, худалдаа;
- Зэвсэг, байлдааны хэрэгсэл үйлдвэрлэл, худалдаа;
- Асбест агуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх ба / эсвэл ашиглах;
- Хууль бус химийн найрлагатай бүтээгдэхүүн, пестицид үйлдвэрлэх, түгээх, борлуулах;
- Ойн болон дагалт бүтээгдэхүүн үйлдвэрлэл эсвэл худалдаа (зөвшөөрөгдөөгүй ойгоос);
- Олон улсад хориглогдсон озоны давхаргыг доройтуулдаг бодисын үйлдвэрлэл, худалдаа;
- Олон улсад хориглогдсон эмийн үйлдвэрлэл, худалдаа;
- Олон улсад хориглогдсон пестицид / гербицидийн үйлдвэрлэл, худалдаа;
- Албадан болон аюултай хэлбэрийн хүүхдийн хөдөлмөр эрхлүүлэлт зэрэгтэй холбогдож болох үйлдвэрлэл болон үйл ажиллагаа;
- Их хэмжээний аюултай химийн бодис үйлдвэрлэх, худалдаалах, хадгалах, тээвэрлэх, эсвэл химийн хорт бодисыг арилжааны хэмжээнд ашиглах;
- Уугуул иргэдийн эзэмшиж байгаа, эсхүл шүүхийн шийдвэрээр нэхэмжилсэн газарт халдах үйлдвэрлэл, үйл ажиллагаа;
- Мод бэлтгэлийн тоног төхөөрөмж худалдан авах;
- Зэрлэг ан амьтан, ан амьтны бүтээгдэхүүний худалдаа;
- Тухайн орны хууль тогтоомж, журам, олон улсын конвенц, хэлэлцээрийн дагуу хууль бус гэж үзсэн аливаа бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, үйлдвэрлэл, худалдаа;
- Улс төрийн аливаа үйл ажиллагаа;
- Санхүүжилтэд үл зөвшөөрөгдөх үйл ажиллагаанд мөн Монгол Улсын Хөдөлмөрийн Сайдын А/36 дугаар тушаалд багтсан насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын жагсаалт орно.



- Дийн Харнуу



**Байгаль орчин**  
**Нийгэмд үзүүлэх**  
**Бидний нөлөө**



## 1. Ерөнхий мэдээлэл

*Төслийн явцад анхаарч  
үзэх ерөнхий зүйлс*

*Хүн ба  
байгалийн  
тогтвортой хөгжил*

## 2. Байгаль орчинд үзүүлэх нөлөөг үнэлэх

*Үүнтэй холбоотойгоор  
танай төслийн хийх үйл  
ажиллагаа*

# Төсөл бичихдээ анхаарах зүйлс

*Тогтвортой  
эдийн засгийн  
хөгжил*

*Нийгмийн эрх  
тэгш байдал*

## 3. Хүн ба нийгэмд үзүүлэх нөлөөг хэмжих

*Үүнтэй холбоотойгоор танай төслийн хийх  
үйл ажиллагаа*



**Энэхүү нөлөөллийн үнэлгээ нь таны төслийн дэмжигдэх эсэхийг тодорхойлох ба аль болох нийгэмд аюулгүй, байгальд ээлтэй төслүүд шалгаруулах зорилготой.**

## 1. Төсөл хэрэгжих байршлын тухай мэдээлэл

- Төсөл хэрэгжих байршлыг нарийвчлан тодорхойлох: Сумын төв, сургууль, аялал жуулчлалын газрууд эсвэл бусад олон нийтийн газартай ойрхон эсэх
- Хэрэв сумын төвөөс зайтай бол малчин айл эсвэл бэлчээртэй ойрхон эсэх
- Гадаа эсвэл дотор үйл ажиллагаагаа явуулах эсэх

## 2. Төслийн хүрээлэн буй орчинд учруулж болох эрсдэл болон нөлөөллийг тодорхойлох

- Байгаль орчин болон нийгэмд учруулах эрсдэлээс урьдчилан сэргийлсэн, байгаль орчин болон нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх арга хэмжээ тусгасан, учирч болох нөлөөллийг бага байлгах арга хэмжээг тусгасан мөн нийгэм соёлын зохистой, байгаль орчинд ээлтэй, үр ашигтай байдлыг тусгасан төслүүдэд илүү давуу талтай.
- Төслийн санаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай материал, техник, нөөцийг тодорхойлож, бизнес эрхлэхэд шаардагдах хязгаарлагдмал нөөцийг хамгийн үр ашигтайгаар хэрхэн ашиглах тухайгаа бичээрэй.

## 3. БОЛОМЖТОЙ ЗҮЙЛС!

- Сөрөг нөлөөллийг арилгах өөр байршил эсвэл технологи санал болгох
- Сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй зарим төслийг сонгохгүй байх
- Байгаль орчинд эрсдэл бүхий гэж үзсэн газруудаас зайлсхийх
- Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах
- Төсөлдөө байгаль орчинд илүү ээлтэй байж болох хувилбаруудыг тусгах

## 4. БОЛОМЖГҮЙ ЗҮЙЛС!

- Төслийн төлөвлөлт, зураг төсөлд өөрчлөлт оруулах
- Төслийн цар хүрээг багасгах эсвэл нүүлгэн шилжүүлэх
- Сөрөг нөлөөтэй арга хэмжээ авах



1



Биологийн  
хорт бодис

Хөрсний  
бохирдол



2



Утаа,  
тоосонцор



3



ТҮЛШ,  
НҮҮРС



Агаар  
бохирдуулагч  
бодис



4

ОРОН НУТГИЙН УСНЫ НӨВЦ



Газар доорхи  
ус ашиглалт

Энэхүү 4 асуудал нь танай төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөг тодорхойлох юм.

Төслийн үйл ажиллагаа байгаль орчинд сөрөг нөлөөтэй юу?



Тийм

Үгүй

1

2

3

4



Энэхүү ТИЙМ хэсгийн 4 асуулт тус бүрийн цонхонд төслийн зүгээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг хэрхэн багасгах талаар бичээрэй.

# Төслийн үйл ажиллагаа байгаль орчинд сөрөг нөлөөтэй юу?

БАЙГАЛЬ  
ОРЧИН

Энэхүү ҮГҮЙ хэсгийн 4 асуулт тус бүрийн цонхонд төслийн зүгээс байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөний талаар бичээрэй.



Тийм

Үгүй

1

2

3

4





*Issues*  
**Хүн ба нийгэмд  
нөлөөлдөг асуудлууд**

Олон  
нийтийн эрүүл  
мэнд, аюулгүй  
байдалд нөлөөлөх  
зүйлс

Боловсролд  
сөргөөр  
нөлөөлөх зүйлс

Хүүхэд болон  
хүний эрхийг  
зөрчих  
магадлалтай  
эсэх

Үндэстний  
цөөнхийн  
бүлгүүд  
хамрагдах уу?  
тэдэнд аюул  
учрах уу?

Олон  
нийтийн соёлд  
сөргөөр  
нөлөөлөхүйц  
үйлдвэрлэл буй  
эсэх

Албадан  
хөдөлмөр  
эрхлэлт



Археологи  
/ Соёлын өвд  
аюул учирч  
болзошгүй  
зүйлс бий юу?

Соёлын  
биет нөөцөд  
аюул учруулах  
аливаа үйл  
ажиллагаа бий  
эсэх

Олон  
нийтийн соёлд  
сөргөөр  
нөлөөлөхүйц  
үйл ажиллагаа

Төслийн үйл ажиллагаа хүн ба нийгэмд эерэг нөлөөтэй юу?



Тийм

- 1
- 2
- 3
- 4
- 5
- 6
- 7
- 8
- 9

Large empty rectangular box for writing answers.

Энэхүү ТИЙМ хэсэгт 9 асуулт тус бүрээр төслийн зүгээс хүн ба нийгэмд үзүүлэх эерэг нөлөөний талаар бичээрэй.



Төслийн үйл ажиллагаа хүн ба нийгэмд эерэг нөлөөтэй юу?

Энэхүү ҮГҮЙ хэсэгт 9 асуулт тус бүрээр төслийн зүгээс хүн ба нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг тодорхойлоорой.



Үгүй



1

2

3

4

5


6

7

8

9

# Төсөл бичнэ гэдэг....





# ТӨСЛӨӨ ИЛГЭЭХ ЗААВАРЧИЛГАА



Бичсэн төслөө эхлээд төслийн үндсэн шаардлагад нийцэж байгаа эсэх, байгаль орчин нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөтэй эсэхийг сумын зөвлөлөөр шалгуулсаны дараа PDF форматад оруулаад хэвлэж эсвэл флаш, цахим шуудангаар тухайн бүсийг хариуцагч Хүүхдийг Ивээх Сангийн ажилтанд хүргүүлнэ.



Төслийг ирсэн он, сар, цаг, хугацаагаар нь Хүүхдийг Ивээх Сангийн ажилтан бүртгэн, хүлээж авна.



Хүүхдийг Ивээх Сангийн зүгээс төслүүдэд оноо өгч шалгаруулна. Оноог ил тод зарлана.



Шалгарсан багууд тэтгэлгийн гэрээнд гарын үсэг зурцгаана. Гэрээний нөхцөл, хугацаа, үүрэг, хариуцлагын талаар уншиж танилцахаа мартаузай.

*Төсөл шалгаруулахтай холбоотой бүхий мэдээллийг ил тодоор зарлана.*

# ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ХЭРХЭН ЯВАГДАХ ВЭ?

Сонгон шалгаруулалт 3 үе шаттай явагдана.

1

## Эхний шат

Төслүүдийг хүлээж авна.  
Эхний шатанд шаардлага  
хангасан төслүүдийг  
шалгаруулна.

2

## Хоёрдугаар шат

Эхний шатанд шалгарсан багууд  
төслийн санаагаа 5 минутын  
хугацаанд танилцуулах Pitch Day арга  
хэмжээнд хамрагдана. Шүүгчдийн  
багаас танилцуулгын оноог гаргана.

3

## Гуравдугаар шат

Тэтгэлэгт тэнцэх эцсийн  
хариуг Хүүхдийг Ивээх  
Сангийн зүгээс танилцуулна.  
Бүх багуудад хэрхэн оноо  
өгсөн тайлбар, цаашид яах  
тухай зөвлөмж хүргэнэ.



\*Сонгон шалгаруулалт явагдах огноо, цаг  
хугацаа, байршлыг төлөвлөгөөний дагуу  
зорилтот бүлгийнхэнд мэдээлнэ.

Хүүхдийг Ивээх  
Сангийн зохицуулагч  
хариуцан ажиллана.



Шүүгчдийн бүрэлдэхүүнийг сонгох  
ажлыг Төслийн аймгийн зөвлөл  
зохион байгуулах бөгөөд үүнд  
Монголын Үндэсний Худалдаа Аж  
Үйлдвэрийн Танхим, Мэргэжил,  
Сургалт Үйлдвэрлэлийн Төв болон  
аймаг, сумдын бизнес эрхлэгчдийн  
төлөөлөл байж болно.




Оролцогч багууд өөрсдийн  
төслийг инновацлаг, **бүтээлч**  
байдлаар танилцуулах тусам  
шалгаруулалтад тэнцэх  
магадлал өндөр байна.

# ШҮҮГЧДИЙН ОНООНЫ "ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД"

## ҮНДСЭН ХЭСЭГ

Оролцогч багууд дараах 5 хэсэг бүхий шалгуур үзүүлэлтийн хүрээнд хариулт тус бүрээс 0-5 оноог авна.

- Санал болгож буй бизнесийн санаа үнэхээр шинэлэг байна уу?
  - Шинжлэх ухаан, технологийн ямар шийдлийг оролцуулсан бэ?
  - Энэхүү бизнес санаанд үнэхээр... ../?/ ..сэтгэж чадсан, онцгой шинж чанар байна уу?
- Алсын хараа нь тодорхой, бизнесийн загвартайгаа тохирч байна уу?



БАЙНА УУ САНАЖ  
ТЕЛЕВИЗИЙН  
? ШОУГ TANK  
SHARK

## МАРКЕТИНГ БА ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

- Зорилтот зах зээл, зорилтот хэрэглэгч
- Тухайн бизнесийг амжилттай байхад хангалттай зах зээлийн боломж байгаа гэдгийг нотлох мэдээлэл
- Өрсөлдөх давуу тал, зах зээлд амжилттай нэвтрэх аргачлал
- Бизнесийн ёс зүйн хувьд ямар нэг асуудалгүй эсэх

## ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Бизнесийн үйл ажиллагааны процесс, бизнес загвар нь сайн, бодитой тайлбарлагдсан эсэх
- Тухайн бизнест технологи, шинжлэх ухаан ашиглагдсан эсэх, тэр нь хэрэгжих боломжтой эсэх

## САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Бизнесийн анхны санхүүжилт, зардал, ашиг нь бодитой тооцогдсон эсэх, мөн энэ бизнес нь өөрийнхөө санхүүгийн тогтвортой байдлыг хангах чадвартай эсэх
- Тухайн төсөл төрөл бүрийн дэмжигчид болон хэрэгтэй хөрөнгө оруулагчдыг татаж чадаж байна уу?

## НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Хүн ба нийгэмд үзүүлэх ЭЭРЭГ, СӨРӨГ нөлөөллийг тодорхойлж, арга хэмжээ төлөвлөсөн эсэх
- Байгаль орчинд үзүүлэх ЭЭРЭГ, СӨРӨГ нөлөөллийг тодорхойлж, арга хэмжээ төлөвлөсөн эсэх




# Тэмцээний дараах үе шат

1

## ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- Шалгарсан баг (төлөөлж сургуулийн захирал), Төслийн сумын зөвлөл болон Хүүхдийг Ивээх сангийн (ХИС) төлөөлөгчид тэтгэлгийн гэрээнд гарын үсэг зурна.



2

## МЕНТОРТОЙ БОЛОХ

- Төслийн аймаг болон сумын зөвлөл нь сумдын тамгын газар, хувийн хэвшлийн төлөөлөгчид, МҮХАҮТ-ын гишүүдтэй хамтран зах зээлд нэвтрэх үйл явцыг хөнгөвчилж, багууд болон багуудтай хамтарч ажиллах боломжит түншүүдийн хоорондын харилцааг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллана.
- Хувийн хэвшлийн төлөөлөгчид шалгарсан багуудад менторинг, дасгалжуулах үйлчилгээ үзүүлэх замаар дэмжих болно
- Сонирхсон багуудад бичил санхүүгийн тусламж эсвэл зээлийн үйлчилгээ хэрхэн авах тухай мэдээллийг өгнө.

3

## ЯВЦЫН ТАЙЛАН, ҮНЭЛГЭЭ

- Тэтгэлэг авсны дараа, төслийн хэрэгжилтийн үеэр хэрэгжилтийн явцыг үнэлэх зорилготой (Байгаль орчин ба нийгмийн асуудалтай холбоотой шаардлагуудыг хангах журамтай нийцэж буй байдал, зах зээлтэй ойр эсэх, төслийн зардал шаардлага хангахуйц эсэх ) ХИС болон Төслийн аймгийн зөвлөл дунд хугацааны хяналт үнэлгээг хийх болно.
- Мөн энэ үеэр багууд тулгарч буй бэрхшээлээ хуваалцаж, түүнийг хэрхэн даван туулах тухайд зөвлөл үйл ажиллагааг зохион байгуулна.





# Тэмцээний дараах үе шат



4

## ЭЦСИЙН ТАЙЛАН

- Бүхий л үйл ажиллагаа дууссаны дараа багууд төсөл хэрэгжүүлэх явцад эзэмшсэн ур чадвар, шинэ мэдлэг, ололт, амжилт, тулгарсан бэрхшээл, сургамжаа дүгнэн нэгтгэж тайлан бичнэ.

5

## ТУРШЛАГА СОЛИЛЦОХ АРГА ХЭМЖЭЭ

- Аймаг, сумдын төслийн хүрээнд хамрагдсан бүхий л багуудын хооронд туршлага солилцох, бусад багуудын шийдэл санаа төсөлтэй танилцах, холбоо үүсгэх зорилготой өдөрлөг зохион байгуулна.



## Санхүүжилтийн засаглалын бүтэц

Орлогч багийн зөвлөх багш

Төслийн сумын зөвлөл ба санхүүгийн ажилтан

Төслийн аймгийн зөвлөл

Хүүхдийг Ивээх Сангийн зохицуулагч

Хүүхдийг Ивээх Сангийн төслийн менежер



Дэлхийн банк





- Родерм Стевенсон

# **Тэтгэлэг**

---

# **авах зааварчилгаа**

---





• Тэтгэлгийн мөнгийг зөвлөлөөр батлагдаагүй, төсөлд төлөвлөгдөөгүй үйл ажиллагаанд зарцуулсан

• Тэтгэлгийн гэрээнд тусгагдсан Давагдашгүй хүчин зүйлсээс бусад шалтгаанаар төслийн явц заасан хугацаандаа явагдахгүй хойшлогдсон

• Багууд тэтгэлгийн гэрээнд тусгагдсан үүргээ биелүүлээгүй

• Ажлын явцын тайлан, гүйцэтгэлийн үнэлгээ, хяналт шинжилгээний үр дүн шаардлага хангахгүй байх

• Төсөл хэрэгжүүлэгч багууд оюуны өмчийн эрхийг зөрчсөн

Хүүхдийг ивээх сан



Тэтгэлгийн гэрээ зурах талууд

Төслийн сумын зөвлөл

Шалгарсан багийн сургуулийн захирал эсвэл зөвлөх багш



Зөвлөх багийн үүрэг:

- Төслийн хэрэгжилтийн бүхий л үе шатанд чиглүүлэн, зөвлөж ажиллах
- Төсөлд тусгагдсан эд зүйлсийн худалдан авалтанд оролцож, удирдан чиглүүлэх

- Тэтгэлгийн зарцуулалтыг зохицуулах, хянах
- ХИС-ийн удирдамжийн дагуу санхүүгийн тайлан болон явцын тайлан гаргах

- Худалдан авалтаас гарах бүхий л баримт, билл, санхүүгийн бүртгэлийг эх хувиар нь бүрдүүлж ирүүлэх
- Төсөл дууссаны дараа зарцуулагдаагүй, дутуу зарцуулагдсан эсвэл хэмнэсэн төсвийг ХИС-ийн дансанд буцааж өгөх

- Шалгарсан багийн сургуулийн захирал эсвэл хариуцсан зөвлөх багш
- Хүүхдийг Ивээх Сан

- Төслийн сумын зөвлөл
- Тэтгэлгийн гэрээ зурах талууд



# Тэтгэлэг хэрхэн хүлээн авах вэ?

- Тэтгэлэг авах үе шат:

Бэлтгэл үе шат

1

Тухайн сумын зөвлөл ба санхүү харцуцсан нягтлан нар багуудын төсөл хэрэгжүүлэхэд тусгайлан зориулж тэтгэлэг хүлээн авах дундын данс шинээр нээх

65%

Эхний шатанд гэрээ зурагдсан цагаас нийт тэтгэлэгийн хэмжээний 65%-ийг шинээр тусгайлан нээсэн дансанд шилжүүлнэ.

Тэтгэлэгийн үе шат

2

Төслийн хугацаанд тэтгэлэг хэлбэрээр орох (65%, 25%, 10%) ба сумын засаг даргын нягтлан энэхүү процессийг харцуцан ажиллана.

- Хавсралт 3-т үйл ажиллагааны зарчмын тухай дэлгэрэнгүй заасан

25%

2 дахь шатны 25%-ийн санхүүжилтийг багуудын (төсөл эхэлснээс 1-3 сарын дотор) ирүүлсэн явцын тайланг харгалзан үзэж, элдэв зөрчилгүй шаардлага хангасан нөхцөлд олгоно.

Санамж

3

Тэтгэлэг авч буй төсөл хэрэгжүүлэгч багууд нь доорх үүрэгтэй бөгөөд хэрэв гэрээнд тусгагдснаас өөр зориулалтаар тэтгэлэгийг ашигласан тохиолдолд гэрээг цуцлах болно:

- Төсөл болон гэрээнд заасан ёсоор тэтгэлэгийг зарцуулах, санхүүгийн тайлангаа бэлдэн илгээх
- Явцын гүйцэтгэлийн тайланг бэлдэн илгээх
- Эцсийн гүйцэтгэлийн тайланг бэлдэн илгээх

10%

Төсөл дуусахад багууд эцсийн тайлангаа явуулсан нөхцөлд сүүлийн шатны санхүүжилтийг нөхөн олгогдах хэлбэрээр үлдсэн 10%-ийг авах юм. Энэ нь багуудыг явцын дунд төслөөс олсон орлого, ашгаа зөв зохистой зарцуулж бие даах чадварыг хөгжүүлэх зорилготой.



Багууд  
төслөө  
илгээх

Шалгаруулалт  
хийх

- Ашиг сонирхолгүйг илэрхийлэх ёс зүйн зарчмыг баримтална.

Шалгарсан  
төсөлтэй  
гэрээ хийх

Тэтгэлгийн  
эхний шатны  
санхүүжилт  
хүлээн авах  
/65%/

Төслийн  
гүйцэтгэл  
100%

2 дахь  
санхүүжилт  
хүлээн авах  
/25%/

Явцын  
тайланг  
үнэлэх

Явцын  
тайлан  
илгээх

- Төсөл эхэлснээс 1-3 сарын дотор явцын тайланг илгээх

Эцсийн  
тайлан  
илгээх

- Санхүүгийн бичиг, худалдан авалтын баримт хавсаргах

Эцсийн  
тайлан  
үнэлэх

Тэтгэлгийн  
сүүлийн  
санхүүжилтийг  
нөхөн олгох  
10%

Тэтгэлэгт  
хөтөлбөрийн  
хаалтын арга  
хэмжээ



# Худалдан авалтын тухайд



Тэтгэлгийн гол зорилго бол өсвөр үеийнхэн, залууст ESEL сургалтаас олж авсан мэдлэгээ ур чадвар болгон хөрвүүлэх боломжийг олгоход оршино. Ийм ч учраас багууд өөрсдийн төсөлд шаардлагатай эд зүйлсийн худалдан авалтыг хийх ба энэхүү үйл явцыг тухайн багийг хариуцсан зөвлөх багшийн зүгээс удирдах, хянах, тайлагнах үүрэгтэй.

- *Багийн гишүүдийн хамтаар зардалдаа тохирсон чанартай, өртөг багатай худалдан авалтыг хийх*
- *Төслийн санхүүгийн зарцуулалтыг зохицуулах, хөтөлбөрийн удирдамжид тусгагдсаны дагуу санхүүгийн тайлан гаргах*
- *Худалдан авалттай холбоотой бүхий л баримтыг эх хувиар нь бүрдүүлэх*
- *Төсөл дууссаны дараа зарцуулагдаагүй, дутуу зарцуулагдсан эсвэл хэмнэсэн төсвийг буцааж өгөх*
- *Ашиг сонирхлын аливаа зөрчлөөс зайлсхийх*

Мөн "Хүүхдийг Ивээх Сан"-ийн мэргэжилтнүүд **худалдан авалт хэрхэн хийх тухай** тусгайлан бэлдсэн сургалтыг оролцогч баг, зөвлөх багш нарт хүргэх болно.



**БАГИЙН ЗӨВЛӨХ  
БАГШИЙН ҮҮРЭГ**



# Төсөлд өөрчлөлт оруулах тухайд

- Багууд шаардлагатай тохиолдолд зөвхөн дараах нөхцлүүдэд өөрчлөлт хийх боломжтой.
- Зөвлөх багш “Өөрчлөлт хийх хүсэлт” маягтыг бөглөх ба төслийн зөвлөл, ХИС-ийн төслийн зохицуулагчдад илгээж зөвшөөрөл авсны үндсэн дээр төсөлд өөрчлөлт оруулна.

## A

- Худалдан авах эд зүйлсийн нэр төрөл, ангилалд өөрчлөлт орох
- Төслийн багийн гишүүдийн өөрчлөлт

## B

- Төслийг цуцлах эсвэл төсөл төлөвлөсөн хугацаанаас өмнө дуусах
- Сунгах зардал байхгүй тохиолдолд

## C

- **Бусад**  
(Хүсэлтийн маягт дээр тайлбарлан бичих)



**Дараах үе шатуудаар  
тэтгэлгийн  
үйл явц дуусгавар болно.**

---





- Элеонор Пүзварт

**Ёс зүй ба**

**ашиг сонирхлын**

**зөрчлийн бодлого**






## Тэтгэлгийн үйл явцтай холбоотой бүх талууд доорх зүйлсийг мөрдөж хамтран ажиллана:

- Уг хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүнг аль ч үед санаж, өөрсдийн санхүүгийн шууд ба шууд бус ашиг сонирхлын өмнүүр тавьж ажиллах
- Ашиг сонирхлын зөрчил (бодит эсвэл болзошгүй) гэж тооцогдох аливаа худалдан авалт, санхүүгийн харилцаанд орохоос татгалзах
- Мөн ашиг сонирхлын зөрчил (бодит болон болзошгүй) явагдаж байна хэмээн үзсэн тохиолдолд түүнийг ил болгох

### Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?

Ашиг сонирхлын зөрчил гэдэг нь тэтгэлгийн үйл ажиллагаатай шууд холбоотой ажилтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг илэрхийлдэг.



Тэтгэлгийн үйл ажиллагаатай холбоотой "шууд бус" ашиг сонирхлын зөрчилтэй этгээд гэдэг нь:

## 1. Тухайлбал

- Тухайн ажилтантай цусан холбоотой болон түүнтэй гэрлэсэн аливаа этгээд (Цаашид "хамаатан" гэх.)
- Тухайн ажилтан эсвэл тухайн ажилтны хамаатан нь ашиг хүртэгч нь байх
- Тухайн ажилтны хамаатан нь түүнд шууд тайлагнах эсвэл хяналтын харилцаатай байх

## 2. Төслийн удирдлага ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авах үүрэгтэй:

- Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах
- Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх
- Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх
- Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх

Энэхүү төслийн хүрээнд учирч болох бодит болон болзошгүй ашиг сонирхлын зөрчлийн жишээг дор дурдав:

- ❌ Худалдан авалтын шийдвэр гаргагч нь одоогийн ба ирээдүйн ханган нийлүүлэгчээс зээл эсхүл бэлэг авсан байх.
- ❌ Санхүүжилт авахаар төслөө ирүүлсэн оролцогч ямар нэгэн байдлаар санхүүжилт олгох шийдвэрт нөлөөлөх боломжтой байх.
- ❌ Суралцагчид болон зөвлөх багшийн гэр бүлийн гишүүн нь шүүгчдийн бүрэлдэхүүн, аймаг болон сумын зөвлөл, Хүүхдийг Ивээх Сангийн төслийн багт байх.







Save the Children



## ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

ХОЛБОО  
БАРИХ ХАЯГ

*Дэлхийн Банкны менежмент, Японы Нийгмийн  
Хөгжлийн Сангийн буцалтгүй тусламжаар  
Хүүхдийг Ивээх Сан хэрэгжүүлж байна.*

- 🌐 <https://www.savethechildren.mn/>
- 📘 <https://www.facebook.com/www.savethechildren.mn/>
- 🐦 <https://twitter.com/savechildrenmn>
- ☎ 976-11-329365
- ✉ [mongolia.secretary@savethechildren.org](mailto:mongolia.secretary@savethechildren.org)

Энэхүү гарын авлагыг орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар,  
энтрепренершип боловсрол олгох төслийн хүрээнд боловсруулав.

